

==БАТЛАВ
УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН
ЗАХИРАЛ ДОКТОР,
ПРОФЕССОР

Д.БАЙГАЛ



БАТЛАВ
УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН
СОНСОГЧ, ТӨГСӨГЧДИЙН
ХОЛБООНЫ ГҮЙЦӨТГӨХ
ЗАХИРАЛ

С.ГАНЗОРИГ



УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН СОНСОГЧ ТӨГСӨГЧДИЙН ХОЛБООНЫ 30 ЖИЛИЙН
ОЙГ ТОХИОЛДУУЛАН НИЙТ СОНСОГЧ, ТӨГСӨГЧ БОЛОН БАГШ
АЖИЛТНУУДЫН ДУНД ЗОХИОГДОХ “GOVERNANCE CUP-2025” СПОРТЫН “З”-Н
ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

2025 оны 11 дүгээр сарын 12

Улаанбаатар хот

Нэг. Тэмцээний зорилго

1.1 Удирдлагын академийн уламжлал болсон сонсогч, төгсөгчид болон багш ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх, анги хамт олны эв нэгдэл, уур амьсгал, идэвх санаачлагыг өрнүүлэх, эргэх холбоо үүсгэхэд тэмцээний гол зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

- 2.1 Удирдлагын академийн нийт сонсогчид
- 2.2 Удирдлагын академийн төгсөгчид
- 2.3 Удирдлагын академийн нийт багш, ажилтнууд

Гурав. Ерөнхий зүйл

3.1. Спортын төрөл, бүрэлдэхүүн

- 3.1.1. Сагсан бөмбөг (эрэгтэй, эмэгтэй баг тус бүр 8 хүртэлх тамирчин)
- 3.1.2. Гар бөмбөг (эрэгтэй, эмэгтэй холимог 8 хүртэлх тамирчин)
- 3.1.3 Дартс (эрэгтэй, эмэгтэй баг тус бүр 2 тамирчин)

3.2. Тэмцээнд оролцох баг тамирчдын мэдүүлгийг хүлээн авах

3.2.1. Тэмцээнд оролцох тамирчдын мэдүүлгийг 2025 оны 11 дүгээр сарын 17-оос 11 дугаар сарын 20-нийг хүртэлх хугацаанд (zayamaa.ami@gmail.com болон 89026790 дугаарын viber-т) цахим хаягаар ирүүлнэ. Тэмцээнд оролцох тамирчид мэдүүлэгтээ заасан баримт бичгийг цээж зургийн хамт хавсарган ирүүлэхдээ тамирчны овог, нэр, утасны дугаар, оюутны код зэрэг мэдээллийг заавал бичнэ. (Хариуцах ажилтны мэдээлэл: Заяамаа Утас:89026790, Ж.Баянтогтох Утас:99911103)

3.3.Тэмцээний техникийн зөвлөгөөн:

3.3.1.Техникийн зөвлөгөөн 2025 оны 11 дүгээр сарын 20-ний өдөр Удирдлагын академийн 203 тоот хичээлийн танхимд 17:40-18:40 цагийн хооронд явагдана.

3.3.2.Техникийн зөвлөгөөнд зохион байгуулагч УАСТХ-ны төлөөлөл, тэмцээнд оролцох ангийн ахлагч 1 тамирчны хамтаар оролцоно.

3.3.3.Техникийн зөвлөгөөнөөр тоглолтын дэг, хуваарь, хугацаа, тоглолтын дараалал, оноолтыг эцэслэнэ.

3.4.Тэмцээний нээлт, хугацаа

3.4.1.“GOVERNANCE CUP-2025” тэмцээний нээлтийн үйл ажиллагаа 2025 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 08:00 цагт эхлэх бөгөөд баг, тамирчид бүрэн бүрэлдэхүүнээр оролцоно. Тэмцээн болох газрыг “Техникийн зөвөлгөө”-өөр зарлана.

Дөрөв.Тэмцээний заавар

4.1.Техникийн зөвлөгөөн дээр тэмцээний төрөл тус бүрээр сугалаа сугалж, оноолт, хугацаа, дарааллыг тогтооно. Тухайн тоглогчийн бичиг баримтыг шалгаж тэмцээнд оролцох эрх (мандат) олгоно.

4.2.Тэмцээнтэй холбогдон гарч болох маргаантай асуудлыг тухайн байгууллагын багийн ахлагч албан хүсэлт гаргаж зохион байгуулагчид өгч, тэмцээний ерөнхий шүүгчтэй хамтран шийдвэрлэнэ. Талбайн шүүгч зөвхөн тухайн тоглолттой холбоотой асуудлыг шийдвэрлэнэ.

4.3.Маргааны нотлох баримтыг үндэслэн “GOVERNANCE CUP-2025” тэмцээнд оролцогч байгууллагын багийн ахлагч нар хуралдаж шийдвэрлэнэ.

4.4.Энэхүү удирдамжаар зохицуулагдаагүй бусад нөхцөл байдал үүсвэл уг асуудлыг тухайн спортын төрлийн олон улсын холбооноос гаргасан дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

4.5.Сагсан бөмбөгийн тэмцээнд талбай дээр эрэгтэй 5, эмэгтэй 5 тамирчин тус бүр оролцоно. Хэсгийн тоглолтууд эрэгтэй 10, эмэгтэй 8 минутаар 2 үе явагдах бөгөөд үе болгоны сүүлийн 3 минут цэврээр явагдана. Тэнцсэн тохиолдолд 5 минут (цэвэр минут) сунгаж ялагчийг тодруулна. Финалын тоглолтууд 10 минутаар 2 ээлж явагдах бөгөөд тэнцсэн тохиолдолд 5 минут (цэвэр минут) сунган ялагчийг тодруулна.

4.6.Гар бөмбөгийн тэмцээнд талбай дээр холимог 6 тамирчдаас (1 багт 2 болон түүнээс доошгүй эмэгтэй тоглогчийг заавал багтаасан байх) бүрдсэн байх бөгөөд 2 үе 25 оноогоор тоглох ба 3 дахь үе 15 оноогоор тоглоно. Багийн бүрэлдэхүүн дутуу үед тоглолтод оролцохыг хориглоно.

4.7. Дартс нь тоглогчид ээлжлэн 3, 3 сум тавьж өрсөлдөх бөгөөд 301 онооноос эхэлж авсан оноогоо хасах журмаар хэн түрүүлж 0 оноотой болсон нь хожно. 0 оноонд хүрэх сүүлийн сумаа заавал бухын нүд эсвэл 2 дахин үржүүлж авах нарийн хэсэгт онож 0 оноотой болж дуусгана. Тоглогч нар шодож хэн түрүүлж шидэхээ шийдвэрлэх бөгөөд самбарын төвд хэн ойр сумаа шидсэн нь тоглолтыг эхлүүлнэ.

4.9. Тухайн төрөлд оролцож буй баг тэмцээн эхлэх цагтаа талбайд гараагүй тохиолдолд 5 минут хүртэл хүлээх бөгөөд хэтэрсэн тохиолдолд тухайн багийг хожигдсонд тооцно.

Тав. Дүгнэх, шагнал урамшуулал

5.1. Тэмцээний зохион байгуулалтын хураамжийн бооцоог 11 дүгээр сарын 21-ний өдрийн Техникийн зөвлөлөөр шийдвэрлэнэ. Холбогдох мэдээллийг: (Хариуцах ажилтны мэдээлэл: Заяамаа Утас:89026790, Ж.Баянтогтох Утас:99911103)

5.2. Тэмцээний бүх төрлийн нийлбэр дүнг бага онооны системээр дүгнэнэ. Тэмцээний бүх төрөлд оноо өгөх байдал: I байр 1 оноо, II байр 3 оноо, III байр 5 оноо, IV байр 7 оноо, V байр 9 оноо тус тус байна. Хэрвээ багийн оноонууд тэнцвэл анги, хамт олны идэвхи, ирцээр шийдвэрлэнэ

5.3. Тэмцээний төрөл тус бүрт I, II, III байр шалгаруулж, багийн дүнгээр шилжин явах цом болон өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС
УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН СОНСОГЧ, ТӨГСӨГЧДИЙН ХОЛБОО-
АНГИЙН ДАРГА НАРЫН ЗӨВЛӨЛ